



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 02 сарын 17 өдөр

Дугаар А/81

Булган сум

**“Хойд бүсийн зөвлөлийн өргөтгөсөн хуралдаан”-ыг
зохион байгуулах ажлын хэсэг байгуулах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, “Шинэ сэргэлтийн бодлого”-ын “Хот хөдөөгийн сэргэлт”, Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн өргөтгөсөн 3 дугаар хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Хойд бүсийн зөвлөлийн өргөтгөсөн хуралдаан”-ыг 2025 оны 04 дүгээр сарын 11-ний өдөр зохион байгуулсугай.

2.“Хойд бүсийн зөвлөлийн өргөтгөсөн хуралдаан”-ыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн дарга: О.Ундрах (Аймгийн Засаг даргын орлогч)

Гишүүд: Д.Наранбаяр (Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Д.Эрдэнэбилэг (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга)

Б.Одхүү (аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга)

Д.Батцогт (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга)

М.Батчимэг (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)

Т.Хонгорзул (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах албаны дарга)

Г.Алдармөнх (Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газрын дарга)

Х.Батхишиг (Биеийн тамир, спортын газрын дарга)

Ү.Бямбасүрэн (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга)

А.Гантөмөр (Байгаль орчны газрын дарга)

Д.Лхагвасүрэн (Татварын газрын дарга)

Т.Бэхтөр (Аймгийн Музейн захирал)

О.Ууганчимэг (Хөгжимт жүжгийн театрын дарга)
Д.Бямбажаргал (Булган сумын Засаг дарга)
Д.Оюунгэрэл (Монголын Үндэсний Худалдаа аж
үйлдвэрийн танхимын Булган салбарын тэргүүн)
Д.Мэндсайхан (Аймгийн Засаг даргын Бизнес, хөрөнгө
оруулалт хариуцсан зөвлөх)
Ж.Ганболд (Аймгийн Засаг даргын Эдийн засаг,
төлөвлөлт хариуцсан зөвлөх)
Б.Мягмаржаргал (Аймгийн Засаг даргын Бүсчилсэн
хөгжил, залуучуудын асуудал хариуцсан зөвлөх)
Н.Мөнх-Эрдэнэ ("Хойд бүсийн хөгжлийн төв"-ийн
Булган аймаг дахь салбарын тэргүүн)
Нарийн бичгийн дарга: Г.Давааням (Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын
хэлтсийн дарга)

3.Өргөтгөсөн хуралдааныг чанарын өндөр түвшинд зохион байгуулан, ажлын үр
дүнг аймгийн Засаг даргад тайлагнахыг ажлын хэсэг (О.Ундрах)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Х.ПҮРЭВ-ОЧИР